

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 13
1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27- ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	6 - 13

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Мандхай, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Д.Энхтүвшин;
Тасалсан: О.Батнайрамдал, Х.Баттулга, О.Цогтгэрэл.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Р.Батболд нарын тавьсан асуултад Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа,

Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын дөрөв дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийн 4.3.8 дахь заалтыг “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана” гэж өөрчилж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Ганхуяг нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 82.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “Монгол Улсыг хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл-8.1.2, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-8.1.2, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд 1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомт сэргэлтийн Үндэсний хороо” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 82.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:

Р.Сэддорж: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл арга хэмжээ”-нд 1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6 км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34, 927.9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д Зам, тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17

82.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “төсөл хэрэгжүүлэх хорооны тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Хорооны тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “15” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд 2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Шинээр боловсруулах төлөвлөгөөний бичиг” гэж, “Хэмжих нэгж”-д “Төлөвлөгөөний тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “5” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 09 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Ж.Алдаржавхлан гишүүн, Р.Батболд гишүүн, Н.Батсүмбэрэл гишүүн, П.Батчимэг гишүүн, Э.Батшугар гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Б.Жаргалан гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүн, Г.Лувсанжамц гишүүн, С.Цэнгүүн гишүүн, М.Энхцэцэг гишүүн хүрэлцэн ирж, ирц 52 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны

ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа орё.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийн эцсийн хувилбарыг Байнгын хорооны болон чуулганы

нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Ажлын хэсэг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Тэгээд гүйцээн боловсруулах чиглэлтэй 2 заалтыг бид 4 салгаж санал хураалт явуулж дэмжигдсэн байгаа.

Тэгээд Байнгын хороонд танилцуулахад бэлэн болсон байна.

Р.Сэддорж: Тогтоолын төслийн эцсийн хувилбараас асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Ж.Ганбаатар гишүүнээр тасаллаа.
Р.Батболд гишүүнээр тасаллаа.

Ж.Ганбаатар гишүүний микрофон өгье.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ ажлын хэсэг их сайн ажиллаж байх шиг байна л даа. Ажлын хэсэгт амжилт хүсье.

Би Зам, тээврийн сайд, Боловсролын сайд хоёроос асуулт байх юм. Өмнө нь ч орж ирэхгүй юм. Одоо ч орж ирэхгүй юм.

Тэр хоёр хүнээс асуулт байх юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Хоёр сайд байхгүй. Тийм ээ?

Ажлын хэсгийн дарга хариулах юм байна. 9 номер тайлбарлая.

9 номерын микрофон нээе.

Б.Болор-Эрдэнэ: Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ.

Б.Дэлгэрсайхан сайд Ерөнхий сайдтай Пакистанд ШХАБ-ын хуралд явж байгаа. Өнөө шөнө бууна.

Р.Сэддорж: Боловсролын яамнаас хүн байгаа юм уу? Байхгүй байна.

Ж.Ганбаатар гишүүн тодруулъя. Ж.Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Энэ Байнгын хороог би бас нэлээн хэдэн жил удирдсан юм л даа.

Энэ жилийнх шиг ийм байдаггүй л байсан юм л даа. Харьцангуй бүр ингээд Их Хурлын ажлыг бүр хойш нь татсан, даварчихсан.

Үүнийгээ хийчхээд тэр гадаад айлчлалтай явж болно шүү дээ. Тэр сайд байж үзээгүй биш. Тэр сайд чинь улсын төлөвлөгөөгөө батлаад, төсвөө баталчхаад гадагшаа явдаг шүү дээ.

Хэнтэй хамт хаашаа явж байгаа нь ямар хамаатай юм. Тэгээд ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Ажлаа амжуулж чадах ёстой байхгүй юу. Тэгж байж сайд болдог юм шүү дээ.

Тэгээд ажлаа амжуулж чадахгүй. Тэр Зам, тээврийн сайдаас би гурван удаа юм асууя гээд байхгүй. Алинд нь ч ирээгүй шүү дээ. Алинд нь ч ирээгүй.

Эдийн засгийн байнгын хороо гэдэг чинь улс орны эдийн засгийг ярьж байгаа биз дээ. Эсвэл өөрсдөө яриад шийдчихдэг юм бол одоо.../минут дуусав/

Р.Сэддорж: Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Сая Их Хурлаар энэ санал нь уначихлаа л даа. Ц.Туваан гишүүний гаргасан Мандал-Түнхлийн замыг л би яриад байгаа юм.

Энэ уг нь хийгдээд яваад байгаа зам байгаа. Сая би Зам, тээврийн яамнаас асуусан чинь хариуцагч нь манайх болчихоод болохгүй байгаа юм. Түүнээс биш орон нутгийн төсвөөрөө явж байгаа гээд байх юм. Төсөв нь уг нь тавигдчихсан. Төсөв дээр байгаад байгаа юм.

Үүнийг буцаагаад энэ 2025 оны төлөвлөгөөнд нь оруулчихмаар байгаа юм.

Үгүй ээ, харин байгаа гэж байна. Яамныхан нь үүнийг хэлээд өгөөч. Энэ төсөв дээр орчихсон юм байна шүү дээ. Тийм ээ. Үүнийг нэг хариулаад өгөөч.

Р.Сэддорж: 9 номерын микрофон.

Б.Болор-Эрдэнэ: Асуултад хариулъя. Зам, тээврийн яам.

Энэ асуудлыг сая чуулган дээр санал хураалтаар яачихсан учраас. Уг нь хөгжлийнхөө төлөвлөгөөндөө оруулчихвал чухал.

Аялал жуулчлалын хувьд, богино зам хийх хувьд, аялал жуулчлалыг хөгжүүлэх хувьд их чухал нэмэртэй зам байгаа. Гишүүнтэй санал бүрэн нийлж байгаа.

Тэгээд дэгийнхээ хувьд болох болохгүй асуудал нь байгаа. Асуулт бол байхгүй.

Р.Сэддорж: Одоо чуулганы нэгдсэн хуралдаанаар уначхаж байгаа юм чинь тэгээд орохгүй биз дээ? Тийм.

Дэмжигдээгүй саналыг хэлэлцэхгүй юм байна шүү дээ. Дэгээрээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрөөтэй саналын томьёоллууд болон нэгдсэн хуралдаанаар санал хурааж дэмжигдсэн боловч шалгуур үзүүлэлт, зорилтыг нь дахин тодорхой болгож тусгах шаардлагатай саналын томьёоллуудыг ажлын хэсэг дахин боловсруулж бэлтгэсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.3 дахь заалтуудыг үндэслэн эдгээр саналуудаар санал хураалт явуулж эхэллэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын дөрөв дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийг 4.3.8 дахь заалтыг хасаж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дахь мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож,

шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг гишүүд. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Х.Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Энэ асуудал өөрөө Хууль зүйн байнгын хорооны асуудал.

Тэгээд би Эдийн засгийн байнгын хороонд байхгүй учраас надад ерөөсөө мэдээлэл ирсэнгүй. Ажлын хэсэг хуралдах гэж байгаа эсэхийг би мэдсэнгүй. Р.Сэддорж даргаас би Байнгын хороо хэзээ хуралдах билээ гээд 11.00 гэхээр нь 11.00-ээс ороод ирсэн чинь ажлын хэсэг наана нь хуралдаад ингээд шийдвэр гаргачхаж.

Энэ асуудлыг гүйцээн боловсруулахдаа хоёр юм байгаа юм.

Нэгдүгээрт, шууд “хасаж” гээд тавьчихаар энэ баримт бичиг чинь нэг талаасаа ингээд эрх зүйн боловч, нөгөө талаасаа бодлогын баримт бичиг байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд улс төрийн алдаанд орох гээд байгаа юм. Яагаад энэ хэсгийг хасаад байгаа юм. Оронд нь юу байна гэдэг нь тайлбар байхгүй болчих гээд байгаа байхгүй юу.

Сая Улсын Их Хурал дээр, чуулганд юу хэлсэн гэхээр Улсын Их Хурлаас батлагдсан хоёр тогтоол зөрчилдөх гэж байгаа учраас

зөрчилдөөнийг арилгах зорилготой гэж хэлсэн.

Тийм учраас өмнө нь зун ээлжит бус чуулганаар батлагдсан 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дотор байгаа тэр бодлогыг энд заавал бичих хэрэгтэй байгаа юм. Нэг.

Хоёрт, яагаад бичих хэрэгтэй байгаа вэ гэхээр энэ 2025 онд заавал хийх ёстой вэ гэхээр Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Сая 9 сард 24 настай хүүхэд эрүү шүүлтэд өртөөд энэ талаараа гомдол гаргаад цагдан хоригдож байхдаа нас барчихсан.

Одоо юу вэ гэхээр энэ эрүү шүүлт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрддөг алба байхгүй байгаа учраас авлига, цагдаа гэх мэтчилэн байгууллагууд нэг нэгэндээ ингээд хэргээ завчилж шилжүүлээд, танайх манайхыг дуугүй байвал манайх танайхыг дуугүй байна гэх байдлаар голд нь хүний эрх зөрчигдөөд байгаа.

Хоёрт нь, тэр хүүхэд чинь эрүү шүүлтэд өртөөд гээд гомдол гаргасаар атал гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо ажиллаагүй.

Яагаад гэвэл цагдаагийн үйл ажиллагаанд өртөөд би эрүү шүүлтэд өртсөн гэхэд Авлигатай тэмцэх газарт гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн ямар ч зохицуулалт байхгүй. Гэрч, хохирогч хамгаалах чиг үүрэг чинь цагдаад байж байдаг.

Тийм учраас энэ бүх үйл явдлаас болоод Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо хоёр хуралдаад ямар зорилго тавьсан бэ гэхээр 2025 онд

багтааж “гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо байгуулна”.

Тэгээд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг тодорхой болгоно”.

“Хохирогчийн эрхийг хангах болон хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатад гаргана” гэсэн зорилт тавьсан юм.

Тэгэхээр энэ зорилтыг нь өөрийг нь бичиж өгөх ёстой.

Тэгэхгүй бол Улсын Их Хурал үйл ажиллагаагаа ингээд хасаад байдаг байхгүй юу гээд. Буруу текст орж ирсэн ч гэсэн дараа нь Улсын Их Хурал ингээд өөрчлөлт хийхээс хасаад байдаг юм гэдэг ийм буруу улс төрийн мессеж үлдэнэ.

Энэ буруу улс төрийн мессеж үлдээхгүйн тулд оронд нь зүгээр “хасах” гээд орхичих биш, “гэрч, хохирогчийг хамгаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагаа нь шинэ шатанд гаргана” гэдэг энэ өгүүлбэрийг нь заавал бичиж өгөх хэрэгтэй.

Тэгээд Улсын Их Хурал үүнийг нь одоо батлаад. Бид бол ингээд зүгээр хоосон хасаагүй шүү. Илүү том зорилт байгаа учраас, илүү одоо нэг байгууллагын дарга тойрсон эрх мэдлийг нэмэх тухай биш, хүн рүүгээ зорьсон, иргэнийхээ эрхийг хамгаалахад зориулсан концесс баталж байгаа учраас энэ өөрчлөлт орж байгаа шүү гэдгийг тодотгож өгөхгүй бол дараа нь улс төрийн тайлбар нь буруу явах гэж байна.

Ийм учраас санал хураалт дээрээ “хасах” гэж биш. 4.3.8-д ийм байдлаар өөрчилж гээд бичих хэрэгтэй байна.

Р.Сэддорж: Х.Тэмүүжин гишүүн тэгвэл наад саналын томьёоллоо хэлээдхээч.

Та наанаасаа хэлчихгүй юу? Микрофон нэе. Гишүүний.

Х.Тэмүүжин: Санал хураах санал.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4 дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийн 4.3.8-ыг “гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах албыг шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатад гаргана” гэж өөрчилж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дахь мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж өөрчлөх.

Өөрчлөх биш. Нэмэх гэж. Сүүлийнх нь.

Р.Сэддорж: Гаргаж байгаа санал дээр тайлбар авъя. Ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг хийе.

Х.Ганхуяг: Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт орсон санал гэж тайлагдаад байгаа.

Тэгэхдээ энэ дээр нэг асуулт нь юу байна гэхээр Улсын Их Хурал хасаад

байгаа юм шиг байдлаар сая Х.Тэмүүжин гишүүн яриад байна л даа.

Ажлын хэсгээс болон Улсын Их Хурлаас энэ хассан заалт бол биш шүү.

Ерөөсөө орж ирээгүй. Тэгээд тайлбараа Та зөв тайлбарлаж байхгүй бол.

Хоёрдугаарт, би юун дээр тайлбар авах гээд байна гэхээр одоо энэ чинь шинэ байгууллага байгуулах юм уу, зохион байгуулалтын өөрчлөлт хийх асуудал үүдээд байна л даа.

Тэгээд үүнтэй холбоотой Засгийн газраас ямар нэгэн санал гарч ирээгүй.

Тэгээд үүнтэй холбоотой ямар нэгэн зардал гарах эсэх. Тэгээд тухайн зардал нь хаанаас гарах эсэх. Энэ дээр нэг тайлбар авчихмаар байна.

Р.Сэддорж: Х.Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Х.Ганхуяг гишүүнд би бас буруу ойлголт өгсөн юм шиг байна.

Одоо байгаа заалтыг хасчихаар оронд нь юу орж ирж байгаа гэдэг нь мэдэгдэхгүй. Одоо байгаа заалтыг хасчихаар дараа нь тэр заалтыг бариад Улсын Их Хурал ийм заалтуудыг хасаад байна шүү дээ гэдэг буруу улс төрийн тайлбар явчих гээд байгаа байхгүй юу.

Тэр агуулгаар нь хэлж байгаа юм. Түүнээс энэ заалтыг хассан тухай биш.

Хоёрт нь, аль аль нь зохион байгуулалтыг өөрчлөх гэж байгаа.

Цагдаагийн байгууллагад байгаа гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий бүтцийг бие даалгаад, тэнд байгаа зардал, мөн шүүхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой шүүхийн харуул хамгаалалтыг хэрэгжүүлж байгаа тэнд байгаа зохион байгуулалтыг гаргаад, тэнд байгаа зардал, гэх мэтчилэн одоо байгаа чиг үүрэг, нөөцийг тусгаарлах байдлаар энэ гэрч хохирогчийг хамгаалах шинэ байгууллага өөрөө бүрдэнэ гэсэн төлөвлөлттэй ажиллаж байгаа. Засгийн газар дээр.

Тэгэхээр дотоод нөөц, эдийн засгийнхаа зохион байгуулалт, боловсон хүчин бүх юмаараа зүгээр шинээр тусгаарлаж эмхлэн зохион байгуулна, бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн үг.

Хуулийн хувьд тусдаа. Мэдээж чухал хууль гарна. Гэрч, хохирогчийг хамгаалах, шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүхэд шүүн таслах үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах гэх мэтчилэн чиг үүргийнхээ хувьд шинэ хууль батлагдаж гарна.

Р.Сэддорж: Саналын томьёоллийг дахиж уншъя.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын дөрөв дэх чиглэл “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн хэсгийн 4.3.8 дахь заалтыг “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана” гэж өөрчилж, мөн хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дахь мөнгөний нөлөөллийг бууруулж,

сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Найдалаа гишүүнийг протоколд дэмжсэнээр тэмдэглэе.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “Монгол Улсыг хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл-8.1.2, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-8.1.2, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд 1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боомт сэргэлтийн Үндэсний хороо” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж.

Энэ хоёр боомт чухал. Яагаад гэхээр баруун бүсийн иргэд, бизнес эрхлэгчдийн амьжиргаа, худалдаа арилжаа, энэ бүх зүйлд энэ 2 боомт зайлшгүй шаардлагатай.

Тэгээд том том боомтууд дээрээ Монгол Улсын 21 аймаг 9 дүүргийн хүмүүс төвлөрчхөөд байгаа учраас энэ боомтуудыг нээж, боломжтой худалдаа, эдийн засгийн эргэлтэд оруулах, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх энэ бүх зүйлд маш хэрэгтэй зүйл байна гэдгийг тэмдэглэж хэлье.

Ингээд санал хураалт. /алх цохив/

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

П.Батчимэг гишүүнийг дэмжсэнээр. Төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл арга хэмжээ”-нд 1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6 км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34, 927.9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д Зам, тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах.

Санал гаргасан. Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

82.4 хувийн саналаар санал
дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “төсөл хэрэгжүүлэх хорооны тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Хорооны тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “15” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд 2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Шинээр боловсруулах төлөвлөгөөний бичиг” гэж, “Хэмжих нэгж”-д “Төлөвлөгөөний тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “5” гэж,

“Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт.

76.5 хувийн саналаар санал
дэмжигдлээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаан идэвхтэй оролцсон Та бүхэндээ баярлалаа.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 11 цаг 33 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД